



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот


“Улаанбаатар фүүд фестиваль” арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай” А/1016 дугаар захирамж, газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Улаанбаатар фүүд фестиваль” арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.


2. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах хавсралтанд дурьдсан 112,073,400 (нэг зуун арван хоёр сая далан гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн
1130 дугаар тушаалын хавсралт



“УЛААНБААТАР ФҮҮД ФЕСТИВАЛЬ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
“УЛААНБААТАР ФҮҮД ФЕСТИВАЛЬ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ					
1.	Маркетинг сурталчилгааны зардал	Багц	1	5,000,000	5,000,000
2.	Тайз, карказ түрээсийн зардал	Багц	3 өдөр	15,300,000	15,300,000
3.	Лед дэлгэц, хөгжим техник, гэрэлтүүлэг түрээсийн зардал	Багц	3 өдөр	19,200,000	19,200,000
4.	Асар түрээсийн зардал (5*5)	ш/өдөр	6 асар 3 өдөр	165,000	2,970,000
5.	Хоолны үзүүлбэр, тэмцээн, уралдааныг дэлгэцээр шууд дамжуулах зардал	Өдөр	3	500,000	1,500,000
6.	Хоолны шоу үзүүлбэрүүдийн түүхий эд материал, тоног төхөөрөмж түрээс, тээврийн зардал (ясгүй бүтэн утсан хонь, 10 метрийн урттай шорлог, 10 метрийн урттай пицца)	Багц	2	4,000,000	8,000,000
7.	Шилдэг байгууллага, тогоочийн шагналын цом хийлгэх зардал	ширхэг	4	500,000	2,000,000
8.	Үйлчилгээний ажилтны хөлс	Хүн/өдөр	17хүн/3 өдөр	100,000	5,200,000
9.	Уралдаан, тэмцээний зардал (6 удаагийн тэмцээний хоолны материалын зардал)	Өдөр/ давтамж	3*2=6	200,000	1,200,000
10.	Харуул, хамгаалалтын зардал	Өдөр/ хүн	9хүн/ 3 өдөр	250,000	2,250,000
11.	Урлагийн тоглолтын зардал	Өдөр/ багц	3	6,000,000	18,000,000
12.	Хөтлөгчийн зардал	Өдөр	3	2,000,000	6,000,000

13.	Талбайн тохижилтын ажил, түрээсийн зардал	Багц	3 өдөр	17,053,400	17,053,400
14.	Талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, хог тээвэрлэлтийн зардал	өдөр	3 өдөр	5,400,000	5,400,000
15.	Эвентийн эдийн засгийн үр өгөөжийн тооцох судалгааны зардал	Багц	1	3,000,000	3,000,000
ДҮН:					112,073,400